



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Чинбатын УНДРАМ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-13-45, Факс: 32-70-16
E-mail: undramch@parliament.mn
<http://www.parliament.mn>

2023.03.16 № УИХ-03/2046
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт 12 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ч.УНДРАМ

П.АНУЖИН

Т.АУБАКИР

Б.САРАНЧИМЭГ

Ц.ТУВААН

Т.ЭНХТҮВШИН

ШАДЬШАА

2022000230



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Чинбатын УНДРАМ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-13-45, Факс: 32-70-16
E-mail: undramch@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.12.07 № ЧУХ-03/11618

танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

Миний бие Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Т.Аубакир, П.Анужин, Б.Саранчимэг, Ц.Туваан нарын хамт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Органик хүнсний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон холбогдох материалыг хавсаргав.

Хавсралт ~~178~~ хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Ч.УНДРАМ

2022000203



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Чинбатын УНДРАМ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-13-45, Факс: 32-70-16
E-mail: undramch@parliament.mn
http://www.parliament.mn

2022.10.20 № УИХ-03/9787

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийн санаачилсан Органик хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайланг хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт зааснаар хуулийн төсөлд санал өгнө үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ч.УНДРАМ

Т.ЭНХТҮВШИН

Т.АУБАКИР

П.АНУЖИН

2022000204



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ч.УНДРАМ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 01. 03 № ХТТ/22
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулж, Засгийн газрын санал, дүгнэлт авахаар ирүүлсэн Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт... хуудас.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэлд:

“VIII.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын санаачлан боловсруулсан Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын санаачлан боловсруулсан Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцээд дараахь саналыг хууль санаачлагчдад уламжлахаар тогтов:

1.Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр тус хуулийн үйлчлэх хүрээнд органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах зэрэг үйл ажиллагааг өргөн хүрээнд хамруулахаар тусгажээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад ““органик үйлдвэрлэл” гэж үйлдвэрлэл, боловсруулалт, бэлтгэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдааны болон энэ хуулийн 4.1.4-т заасан шилжилтийн үеийн бүх үе шатанд энэ хуульд заасан шаардлагад нийцсэн арга, технологийг ашиглахыг;” гэж тусгасан байна. Өөрөөр хэлбэл органик бүтээгдэхүүнийг бэлтгэх үе шатаас худалдаалах үе шат хүртэлх үйл явцыг ойлгохоор байна.

Гэтэл хуулийн төсөлд органик бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, хадгалах үе шаттай холбоотой зохицуулалт, тэдгээрт тавигдах шаардлага болон органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх процессын үе шатанд авах арга хэмжээтэй холбоотой зохицуулалт тусгагдаагүй орхигдсон байх тул хуулийн төслийн хамрах хүрээнд тусгасан үйл ажиллагаа тус бүрийг нарийвчлан тодорхой тусгах.

2.Хуулийн төсөлд органик бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэгчид төрөөс дэмжлэг үзүүлэх, мөнгөн урамшуулал олгох, татвараас хөнгөлөх, чөлөөлөх, зарим төрлийн зардлыг төрөөс бүрэн хариуцах зэрэг зохицуулалтыг тусгажээ.

Тухайлбал, хуулийн төслийн 15 дугаар зүйлд төрөөс органик бүтээгдэхүүний шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал, олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах зардалд 50 хувиас доошгүй хувийн мөнгөн дэмжлэгийг үзүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хүнсний тухай хуульд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг, урамшуулал үзүүлэх талаар зохицуулсан байх бөгөөд мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “органик хүнсний үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг, урамшуулал олгоно” гэж, мөн Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6-д “тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн

этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэг үзүүлнэ” гэж тус тус зохицуулсан байна.

Түүнчлэн, Засгийн газраас хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2010-2021 онуудад нийт 753.0 тэрбум төгрөгийн урамшуулал, дэмжлэгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн ба татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор дамжуулан дэмжлэг үзүүлж байна.

Өөрөөр хэлбэл, дээрх хуулиудын зохицуулалтаас харахад хүнсний буюу органик бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зориулж төрөөс мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр дэмжлэг, урамшууллыг олгодог байна.

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд заасан органик үйлдвэрлэлд төрөөс дэмжлэг үзүүлэх, мөнгөн урамшуулал олгохтой холбоотой зохицуулалт нь Хүнсний тухай хууль болон Тариалангийн тухай хуулийн зохицуулалттай давхардал үүсгэж, улсын төсвөөс урамшуулал, дэмжлэгтэй холбоотойгоор давхардсан зардал бий болгож байгааг анхаарч, хуулийн төсөлд туссан дэмжлэг, урамшуулалтай холбоотой зохицуулалтыг нягтлах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР